



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 09

Сүмбэр сум

Говьсүмбэр аймгийн Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52 дугаар зүйлийн 52.1.8, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, биелэлтийг хууль, тогтоомжид заагдсан хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ

4224001058

Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12-р сарын 05-ны өдрийн ээлжит 3 дугаар
хуралдааны 29 дугаар тогтоолын хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР


Үндэслэл: Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийн 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ын дагуу боловсрууллаа.

Мөн Эдийн засгийн төлөвлөлт, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр хийдэг “Аймгийн өрсөлдөх чадварын судалгаа”, Статистикийн Үндэсний хорооноос гаргасан Хүний хөгжлийн индекс, аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийн суурь судалгаануудыг үндэслэж, төслүүдийн эдийн засгийн үр өгөөж, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл, санхүүжилт, зохион байгуулалтын эх үүсвэрийг салбарын болон орон нутгийн бодлого, төлөвлөлтүүдтэй уялдуулан тооцсон болно.

Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал

Эдийн засаг: Говьсүмбэр аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл нь уул уурхай, тээвэр логистик, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбар бөгөөд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого болох “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого” -ын хүрээнд эдийн засгийн хувьд бие даан, хүндээ ээлтэй, эдийн засаг, нийгмийн хөгжлөөр улсдаа жишиг аймаг болон хөгжих зорилтыг хэрэгжүүлж байна.

2020-2024 оны хугацаанд Говьсүмбэр аймгийн эдийн засаг тэлж, дотоодын нийт бүтээгдэхүүн 124.5 –аас 199.3 тэрбум төгрөгт хүрч 37.5 хувиар өсч, эдийн засгийн өрсөлдөх чадвараар улсдаа 5 дугаарт эрэмбэлэгдэж байна.



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-аас харахад өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 81.73 хувьтай 5 дугаарт, үүн дотроо Дэд бүтэц 97.26 хувьтай 3 дугаарт, Засаглалын үр ашиг 93.9 хувьтай 5 дугаарт, бизнесийн үр ашиг 80.42 хувьтай 8 дугаарт, эдийн засгийн тамир тэнхээ 52.66 хувьтай 13 дугаарт тус тус эрэмбэлэгдэж байна.

Үүнээс хамгийн анхаарал татаж байгаа үзүүлэлт нь эдийн засгийн тамир тэнхээ бөгөөд эдийн засгийн өсөлтөөр 14 дүгээрт, эдийн засгийн салбаруудын хөгжлөөр 19 дүгээрт хүн амын амьжиргааны түвшингээр 6 дугаарт хөдөлмөр эрхлэлтээр 10 дугаар тус тус байна. Иймээс бид олон тулгуурт эдийн засгийн салбаруудыг дэмжин, эдийн засгийн өсөлтийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээг ирэх 4 жилийн бодлогод тусган хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар “IRIM” судалгааны хүрээлэнгээс хийсэн “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-наас харахад соёлын үйлчилгээ 1 дүгээрт, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн үйлчилгээ 3 дугаарт, төрийн цахим үйлчилгээ, татвар гаалийн үйлчилгээ тус бүр 5 дугаарт, боловсрол, шинжлэх ухаан, хууль эрх зүй, эрүүл орчин, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, засаглалын үзүүлэлтээр тус тус 6 үнэлэгдсэн бол судалгааны үр дүнгээс харахад зам тээвэр, барилга, хот байгуулалт, хот тохижилт, хог хаягдлын менежментийг сайжруулах шаардлагатай гэж иргэд үзсэн байна.


2020-2024 онд олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх бодлогын хүрээнд татварын бааз суурийг нэмэгдүүлэн зорилтыг тавин ажилласнаар 2020 онд татвар

төлөгчийн тоо 623 байсан бол 2024 онд 817 болж өссөн бөгөөд Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 2024 оны 114.0 хувьтай, Орон нутгийн төсвийн орлого 2024 оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 16000.0 сая төгрөг болсон нь өмнөх оноос 31,2 хувиар өссөн.

Татварын бааз суурь өсөхийн хирээр улс, орон нутгийн төсвийн орлого өсч, улсаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа бөгөөд 2021 онд 10.89 тэрбум, 2022 онд 11.85 тэрбум, 2023 онд 14.9 тэрбум, 2024 онд 73.9 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж өмнөх оноос 79.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Хөдөө аж ахуй: Аймгийн хэмжээгээр 2023 оны жилийн эцэст 5390 өрх



бүртгэгдсэний 1171 буюу 21.7 хувь нь малтай өрх байна. Аймгийн хэмжээний нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийг авч үзвэл, 2003 онд 14.7 хувийг, 2013 онд 12 хувийг эзэлж байсан бол 2023 онд 14,4 хувийг эзэлж байна.

Мал тооллогын 2023 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 450.1 мянгад хүрч, өмнөх оныхоос 14.8 мянган толгойгоор буюу 3.1 хувиар буурсан бөгөөд төрлөөр нь авч үзвэл, адуу 30.8 мянга, үхэр 22.3 мянга, тэмээ 1.0 мянга, хонь 227.8 мянга, ямаа 168.2 мянган толгой тоологдлоо. Малын өсөлтийг төрлөөр авч үзвэл, 2023 онд үхэр 2.6 мянга (13.2%), адуу 3.1 мянга (11.2%), толгойгоор тус



тус өсөж, тэмээ 20 (1.9%), хонь 8.2 мянга (3.4%), ямаа 11.6 мянга (6.4%) тус тус толгойгоор буурсан байна.


Сүргийн бүтцийн хувьд бог малын 75.0 орчим хувийг хонь, 25.0 орчим хувийг ямаан сүрэг эзлэх нь бэлчээрийн зохистой харьцаа болж байдаг. Харин бог малд хонин сүргийн эзлэх хувь 57.5, ямаа сүргийн эзлэх хувь 42.5 байгаа нь сүргийн бүтэц болон бэлчээрийн зохистой харьцаа алдагдсаар байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа ашиг шим өндөртэй мал үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ авах нь чухал юм.

Хүн ам: Аймгийн хүн амын тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 18112 (9030 эрэгтэй, 9082 эмэгтэй) болж өмнөх оноос 0.4 хувиар өсөж, дундаж наслалт 73.9 хувьд хүрч, Статистикийн үндэсний хорооноос жил бүр тодорхойлдог хүний хөгжлийн индекс 78.0 хувьд хүрч улсын хэмжээнд 4 дүгээрт эрэмбэлэгдэж байна.

Аймгийн нийт хүн амын 73.2 хувь нь Сүмбэр, 20.7 хувь нь Шивээговь, 6.1 хувь нь Баянтал суманд тус тус амьдарч байна. Мөн аймгийн төвд 10918, Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын төвд 3436, хөдөөгийн багт 3758 иргэн буюу төв суурин газарт нийт хүн амын 79.2 хувь нь амьдарч байна.

Аймгийн төвүүдийн боловсрол, эрүүл мэнд, ажлын байр, худалдаа, үйлчилгээ, зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөгөөс илүү байгаа нь шилжин ирэгчдийг татаж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөдөг. Говьсүмбэр аймаг нь төмөр зам, авто замын сүлжээ зэргээс шалтгаалан хотын хүн ам өсөх хандлага ажиглагддаг. Мөн Дундговь, Дорноговь аймгийн харьяа захын сумдаас шилжин ирэгсэд их байдаг.



Хүн амын дундаж наслалтыг авч үзвэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 73.9 байгаа нь улсын дунджаас 2.6-аар их, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 73.5, эмэгтэйчүүдийнх 75.6 байна. Хүн амын насны суваргаас харахад 2010 онд идэрших хандлагатай насны бүтэцтэй байсан бол 2023 оноос энэ хандлага өөрчлөгдөж, илүү залуу насны бүтэцтэй болсон байна. Иймд бид бодлогын баримт бичигтэй залуучуудын хөгжлийн асуудлыг тодорхойлон тусгах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Хүн амын өсөлт, насны бүтэц, шилжилт хөдөлгөөн зэрэгтэй холбоотойгоор боловсрол, эрүүл мэнд, нийгмийн бусад салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ач холбогдол: Энэхүү бодлогын баримт бичиг нь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны бодлого бөгөөд 2024-2028 онд бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг системчилж, Бүсчилсэн хөгжлийн бодлого, төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэндээ ээлтэй бодлого шийдвэр, төсөл арга хэмжээг уялдуулан, эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр дүн, үр нөлөөг бодитоор тооцох боломжийг бүрдүүлж байна.

Зорилго: Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, хүний хөгжил, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих замаар эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг бий болгох зорилготой.


Зорилт: Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эдийн засгийг дэмжих мега төслүүдийг хэрэгжүүлэх.
2. Говийн бүсийн хөгжлийг дэмжиж, бүсийн эдийн засагт үзүүлэх үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх.
3. Хүний хөгжлийг дэмжих.
4. Эдийн засгийг эрчимжүүлэх.
5. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогыг хэрэгжүүлэх.

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУССАН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ МЕГА ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

1.1. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Чойрт 100 МВт-ын салхины, 40 МВт-ын цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлж өсөн нэмэгдэж байгаа

дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхнө. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.



1.2. Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойг барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мянган тонн хүлэмжийн хийг бууруулна. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна.

1.3. Нүүрс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

ХОЁР. ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, БҮСИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР ДҮН, НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛЭХ

2.1. Хот төлөвлөлтийн эрчимжүүлж, гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж, орон сууцжуулах

2.1.1. Эрчим хүчээр хангагдсан хот

2.1.1.1. Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн 30МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

2.1.1.2. Аймгийн төвийн 20МВт-ын дулааны станцыг гадаадын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж ашиглалтын менежментийг хэрэгжүүлнэ.

2.1.1.3. Цахилгаан дамжуулах шугам сүлжээг өргөтгөж, эрчим хүчний найдвартай байдлыг хангаж, шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчинд холбоно.

2.1.1.4. Аймаг, сумдын уурын зууханд технологийн шинэчлэл хийж, дулаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.1.2. Хот төлөвлөлт, орон сууцжуулалт

2.1.2.1. Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд орон сууц, амины орон сууцыг шинээр барьж, иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



2.1.2.2. Аймаг, сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг өргөтгөж, шинэчлэн, найдвартай байдлыг хангах, гэр хороолол, нийтийн байрнуудыг цэвэр ус, дулаан хангамжийн төвлөрсөн шугамд шат дараалан холбоно.

2.1.2.3. Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтад оруулж ашиглалтын менежментийг сайжруулна.

2.1.2.4. Өмчлөл, эзэмшлийн газрыг хуулийн хүрээнд үргэлжлүүлэн олгож, гудамж талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хаягжуулалтыг шинэчлэн сайжруулна.

2.2. Ногоон-Ухаалаг хотыг хөгжүүлэх

2.2.1. Сүмбэр сумын төвд “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлж, камерын хяналтын системийг сайжруулж, аюулгүй байдлыг бүрдүүлнэ.

2.2.2. Аймаг, сумдын төвийн авто зам, явган болон дугуйн замын сүлжээг өргөтгөнө.

2.2.3. Аймгийн төвийн суурьшлын бүс, дэд бүтцийг үерийн усны аюулаас хамгаалах ус зайлуулах далан, суваг, хөв цөөрмийг байгуулж, хуримтлагдсан усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглана.

2.2.4. Аймаг, сумдын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн талбайг тохижуулан, хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлнэ.

2.2.5. Аймаг, сумын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулна.

2.2.6. Чойр хотын төвд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлж, автобусаар хангана.

2.2.7. Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, тохижилт, үйлчилгээг сайжруулж, СӨХ байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

2.3. Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, аж үйлдвэр,

Тээвэр-логистикийг хөгжүүлэх

2.3.1. Баянтал суманд “Мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн парк” байгуулна.

2.3.2. “Хот хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд хуурай замын боомт, агуулах, терманал, тээвэр-логистикийн төв байгуулна.

2.3.3. Улс, бүсийн чанартай авто замыг өргөтгөх, шинээр барих, засварлаж, ашиглалтад оруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.3.4. “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд шилжин ирсэн иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

3.1. Чинээлэг Монгол хүн

3.1.1. Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого

3.1.1.1. Гэрлэх ёслолын ордон байгуулж, гэр бүлийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1.2. Хүүхэд хөгжлийн болон хамгааллын үйл ажиллагааг дэмжин, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.1.3. “Жендэрийн тэгш байдлыг хангах, нийгмийн зорилтот бүлгийн хөгжлийг дэмжих” хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

3.1.2.1. Жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжин хөгжүүлнэ.

3.1.2.2. Иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

3.2. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

3.2.1. Иргэд, хүүхэд, залуусыг биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, биеийн тамирын талбай, спорт заалны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Нийтийн биеийн тамирыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, спортын мэргэжлийн холбоо, клубуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

3.3. Эрдэм боловсролтой Монгол хүн

3.3.1. Сургууль, цэцэрлэг, ПТК-ийн сургалтын болон дотуур байрны барилгыг өргөтгөх, засварлах, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах.

3.3.2. Боловсролыг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш, ажилчдыг чадавхжуулах, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулж, орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутан залууст сургалтын тэтгэлэг олгоно.

3.4. Эрүүл Монгол хүн

3.4.1. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгыг өргөтгөх, засварлах, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах.

3.4.2. Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж, эмчилгээ, оношилгооны шинэ технологийг нэвтрүүлж, нутагшуулна.



3.4.3. Нийгмийн эрүүл мэндийг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

4. ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ

4.1. Төсөв, санхүү, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

4.1.1. Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлж, улсын төсвөөс авах татаасыг үе шаттайгаар бууруулна.

4.1.2. Орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлнэ.

4.1.3. Гадаад, дотоодын болон улс, орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төрийн худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

4.2. Уул уурхай

4.2.1. Уул уурхайн тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгож, хяналтыг сайжруулна.

4.2.2. Уул уурхайн олборлолт, тээвэрлэлт эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан, хамтран ажиллана.

4.3. Хөдөө аж ахуй – “Шинэ хоршоо” хөдөлгөөн

4.3.1. Эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулах, малын ашиг шимийг нэмэгдүүлэн, малчдыг дэмжинэ.

4.3.4. Хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг бодлогоор дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлж, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.4. Дөрвөн улирлын аялал жуулчлал

4.4.1. Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгож аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг олон улс, улсын чанартай үзэсгэлэнд оролцуулж, үйл ажиллагааг нь сурталчлана.

4.5. Соёл урлаг, өв уламжлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл

4.5.1. Соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, соёлын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

4.5.2. Соёл урлагийн байгууллагуудын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах, засварлах, техник, тоног төхөөрөмжөөр хангана.



4.6. Байгаль орчин, уур амьсгал

4.6.1. Чойрын Богд уул болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийг сайжруулж, биологийн төрөл зүйл, аргаль хонийг хамгаалах, ховордсон ан амьтныг нутагшуулж, биотехнологийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.6.2. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний үргэлжлүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

4.6.3. Усны менежментийг сайжруулж, усан хангамжийн эх үүсвэр, нөөц, гол горхи, булаг шандын эхийг хамгаална.

4.6.4. Цаг уур, орчны хяналтыг сайжруулж, агаар, орчны бохирдлыг бууруулж, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.

ТАВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

5.1. Хүний эрх, эрх чөлөө

5.1.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хүний эрхийг хангана.

5.2. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа

5.2.1. Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

5.3. Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээ

5.3.1. “Цахим Говьсүмбэр” хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулж, дэд бүтцээр хангана.

5.4. Төрийн албаны шинэчлэл

5.4.1. Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. (Төрийн албан хаагчийн ёс зүй, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, гадаад, дотоодод сургалт, туршлага судлуулах арга хэмжээнд хамруулна.)

5.4.2. Төрийн байгууллагуудын үйлчилгээний орчинг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

5.5. Үндэсний эв нэгдэл, аюулгүй байдал

5.5.1.1. Батлан хамгаалах хууль тогтоомж, орон нутгийн хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

5.5.1.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

5.5.1.3. Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа: Энэхүү хөтөлбөрийг 2024-өөс 2028 оны хооронд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт:

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар биечлэн хариуцах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хяналт тавьж, жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

№	Шалгуур үзүүлэлт	Зорилготой түвшин					Эх сурвалж	Мэдээллийн давтамж	Хариуцах байгууллага
		Суурь түвшин 2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он			
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ									
1	Эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс	0.817	0.82	0.83	0.84	0.85	0.86	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв	Жилд 1 удаа АЗДТГ
2	Дотоодын нийт бүтээгдэхүүн /сая.төг/	199.2	204.2	209.2	214.2	219.2	224.2	Статистикийн мэдээлэл	Жилд 1 удаа Статистикийн хэлтэс
3	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ /Мян.төг/	11.02	11.8	12.7	13.6	14.7	15.8	Статистикийн мэдээлэл	Жилд 1 удаа Статистикийн хэлтэс
4	Төсвийн орлого бүрдүүлэлт (сая.төг)	24 049.6	18 628.6	20 098.6	20 491.5	22 540.6	24 794.7	Статистикийн мэдээлэл	Жилд 1 удаа АЗДТГ
5	Төсвийн зардал /сая.төг/	19 107.3	20 098.6	44 581.3	49 039.5	53 943.4	59 337.8	Аймгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Жилд 1 удаа АЗДТГ
6	Төсвийн тэнцэл /сая.төг/	4 942.3	3 000.00	2 000.00	1 500.00	1 500.00	1 500.00		Жилд 1 удаа АЗДТГ
7	Улсаас авах санхүүгийн дэмжлэгийн бууралтын хувь	72.8	-187.5	-71.5	4.3	4.5	4.7	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	Жилд 1 удаа Хүнс, хөдөө аж ахуйн газар
8	Хэрэглээний үнийн индекс	99.8	101.3	101.0	100.7	100.4	100.1	Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан	Жилд нэг удаа Хүнс, хөдөө аж ахуйн газар
9	Малын тоо /мян.толгой/	450.1	353.3	354.0	354.0	354.0	354.0	Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан	Жилд 1 удаа Хүнс, хөдөө аж ахуйн газар
10	Хураан авсан малын тэжээл, бусад таримал /мян.тн/	0.1	0.15	0.16	0.17	0.18	0.19	Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сан	Жилд 1 удаа Хүнс, хөдөө аж ахуйн газар
11	Хураан авсан төмс, хүнсний ногоо /мян.тн/	0.35	0.5	0.6	0.7	0.8	0.9	Татварын хэлтэст бүртгэлтэй ААНБ-ын тоо	Жилд 1 удаа Татварын хэлтэс
12	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо	500	245	310	320	330	350	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа Соёл урлагын газар
13	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	471	220	250	300	350	400	ГХБХБ-ын газрын тайлан, мэдээ	Жилд 1 удаа Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
14	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	73	71	72	80	81	85		





ХӨӨР, НИЙГМИЙН БОЛОН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ												
15	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	97.9	88.5	89	90	90.5	91	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	Жилд 1 удаа	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар		
16	Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрхийн тоо	-	-	50	200	300	400	Барилгын салбар	Жилд 1 удаа	ГХБХБГ		
17	Шинээр баригдсан орон сууцны хүчин чадал / өрхийн тоогоор/	-	36	45	320	620	1020	Барилгын салбар	Жилд 1 удаа	ГХБХБГ		
18	Хүний хөгжлийн индекс	0.780	0.785	0.790	0.795	0.800	0.805	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
19	Хүн амын дундаж наслалт /тоо/	73.8	73.9	73.9	74.0	74.1	74.3	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn 2023 оны үзүүлэлтээр	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
20	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	8.7	8.5	8.3	8.1	8.0	7.8	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
21	10,000 хүн амд вирус гелатитын өвчлөл	1.7	2.3	2.3	2.2	2.0	2.0	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
22	Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	99.6	99.6	99.7	99.7	99.7	99.7	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
23	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	77.6	86.9	85.5	86.0	86.5	87.0	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
24	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	86.2	86.6	87.0	87.2	87.4	87.6	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
25	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	72.3	72.3	78.5	78.9	79.0	79.3	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн газар		
26	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувь/	96.06	98.4	99.0	100	100	100	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар		
27	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувь/	100	100.0	100	100	100	100	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар		
28	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	31	30	29	28	27	26	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар		
29	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	29	30.8	30.5	30	29	28	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар		
30	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	523	526	526.5	527	527.5	528	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар		

31	Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан цэцэрлэгийн эзлэх жин	-	42.7	28.5	42.7	56.9	71.1	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
32	Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан сургуулийн эзлэх жин	-	20	40	60	80	80	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
33	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх жин	-	56	65	65	70	75	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
34	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн хувь	-	30	35	50	55	60	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
35	Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	-	90.5	91	91	92	92	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
36	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	-	77.4	78	78	79	80	www.esis.edu.mn	Жилд 1 удаа	Боловсролын газар
37	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	76.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн программ	Жилд 2 удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар
38	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	80	100.0	100.0	100.0	100.0	100.0	ХХҮГ-ын статистик мэдээлэл	Жилд 2 удаа	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
39	Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	Хоршоо хөгжүүлэх сангийн программ	Жилд 2 удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар
40	Ажилгүйдлийн түвшин /хувь/	7	6.8	6.6	6.4	6.2	6.0	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	Жилд 1 удаа	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
41	Ажиллах хүчний оролцооны хувь	56.2	56.5	56.8	57.1	57.4	57.7	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	Жилд 1 удаа	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
42	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	108	110	120	130	140	150	e-job цахим систем	Жилд 2 удаа	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс

43	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	100	100	100	100	100	100	100	100	100	100	Нийгмийн даатгалын хэлтсийн статистик мэдээ	Жилд 2 удаа	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
44	Нэг хүнд ногдох спорт залны талбайн хэмжээ, м2	-	3.1	3.2	3.5	3.8	4.0					Биений тамир спортын статистик	Жилд 2 удаа	Биений тамир спортын газар
45	Нэг хүнд ногдох спортын гадна талбайн хэмжээ, м2	-	35.2	35.4	35.7	35.8	36.0					Биений тамир спортын статистик	Жилд 2 удаа	Биений тамир спортын газар
ГУРАВ. ЗАСАГЛАЛ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ														
46	Төрийн цахим үйлчилгээний тоо /өссөн үзүүлэлтээр/	84	89	95	100	105	110					e-mongolia, e-baigim, e-job программ	жилд 2 удаа	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс
47	Цахим хөгжлийн индекс	0.96	0.92	0.93	0.96	0.98	1					Судалгаа	жилд 1 удаа	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс
48	Ил тод байдлын индекс	0.62	0.63	0.64	0.65	0.66	0.67					судалгаа	жилд 2 удаа	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс
49	Шударга байдлын үнэлгээ	69.5	69.6	69.7	69.8	69.9	70.0					АТГ-ын статистик	жилд 1 удаа	АЗДТГ
50	Жендерийн тэгш бус байдлын индекс	0.338	0.337	0.336	0.335	0.334	0.335					Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	Жилд 1 удаа	АЗДТГ
51	Бүртгэгдсэн гэмт хэрэг /тоо/	139	162	161	160	159	158					Цагдаагийн байгууллагын статистик	Жилд 2 удаа	Цагдаагийн хэлтэс
52	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо	4	20	19	18	17	16					Цагдаагийн байгууллагын статистик	Жилд 2 удаа	Цагдаагийн хэлтэс
53	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин /хувь/	51.2	56	57	58	59	60					Цагдаагийн байгууллагын статистик	Жилд 2 удаа	Цагдаагийн хэлтэс
ДӨРӨВ. УУР АМЬСГАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ														
54	Агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж /Mкг/м3/	0.014	0.026	0.026	0.026	0.026	0.026	0.026	0.026	0.026	0.026	Мар.purpleair.com сайт	Жилд 1 удаа	Ус цаг уур, орчны шинжилгээ
55	Нийт таригдсан модны тоо /өссөн дүнгээр/	151000	217000	427000	754000	1150000	1688000					Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар

56	Төвийн ногоон байгууламжийн нийт талбай, га	36,2	41,2	50	60	70	80	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
57	Ойн сангийн хэмжээ, га	47	47	47,5	48	48,5	49	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
58	Модны ургалтын дундаж хувь	82	83	84	85	86	87	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
59	Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ, тн	2,5	0,8	1,0	1,5	2,0	3,0	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
60	Хур болон барилгын туурь хог хаягдалтай газар, га	190,1	183	175	165	155	145	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
61	Хур болон барилгын туурь хог хаягдалтай газрыг цэвэрлэсэн талбайн хэмжээ, га	2,1	6,6	10	12	15	18	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
62	Хамгаалагдсан булаг шанд, хөв цөөрмийн тоо	4	5	6	7	8	9	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар
63	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, га	1729,2	4155,37	4155,37	4200	4250	4300	Байгаль орчны мэдээллийн сан	Жилд 1 удаа	Байгаль орчны газар